



ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН
ЗӨВЛӨЛ



2018

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

www.mediacouncil.mn

ӨМНӨТГӨЛ




Хэвлэл мэдээллийн зөвлөл 2018 онд сэтгүүл зүйн хууль эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллага болон шүүх, хяналтын байгууллага хоорондох ойлголцлыг бий болгоход чиглэсэн цуврал арга хэмжээг хийсэн нь онцлог байв. Ялангуяа 2017 оны долдугаар сарын нэгний өдрөөс хэрэгжсэн Зөрчлийн хуулийн “Гүтгэх, доромжлох” заалт нь сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх магадлалтай болсон. Энэ нь хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх үндсэн эрхэд халтай болох нөхцөл байдал руу хөтөлж болзошгүй байгаагаас үүдэн цуврал хэлэлцүүлгийг холбогдогч талуудыг оролцуулан зохион байгууллаа.

Бид сэтгүүлчид, олон нийтэд зориулсан 23 сургалт, дугуй ширээний ярилцлага, хэлэлцүүлэг, форумыг бие даан зохион байгуулж, 12 сургалт, үйл явдалд үндсэн болон туслах илтгэл хэлэлцүүлсэн байна. Ойролцоогоор 1000 гаруй хүнд хэвлэл мэдээллийн эрх зүйн болон өөрийн зохицуулалт, ёс зүйн чиглэлээр мэдлэг, ур чадвар олгов.

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ


Хэвлэл мэдээллийн зөвлөл нь Сонин, сэтгүүл, сайтын ёс зүйн хороо, Радио ТВ-ийн ёс зүйн хороотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Ёс хороод нь иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдлыг “Гомдол хүлээн авах, барагдуулах журам”, “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”-д тулгуурлан хэлэлцэж дүгнэлт гаргадаг. 2018 онд ССС-ын ёс зүйн хороо дөрвөн удаа, РТВ-ийн ёс зүйн хороо гурван удаа хуралдсан байна.

2018 онд Хэвлэл мэдээллийн зөвлөл 100 өргөдөл, гомдол хүлээн авсан бөгөөд үүний 86 хувь нь сонин сэтгүүл болон мэдээллийн сайдуудад, 14 хувь нь телевизүүдэд хаяглагджээ.



Хугацаа хэтэрсэн, өргөдөл гомдол хүлээн авах, барагдуулах журамд хамаарахгүй, материалаа бүрэн бүрдүүлж өгөөгүй зэрэг шалтгаанаас 44 гомдлыг ажлын албанаас урьдчилсан хяналт хийж шийдвэрлэсэн. Харин долоон гомдол гаргагч өргөдлөө явцын дунд буцаан татжээ. Түүнчлэн ёс зүйн хороогоор хэлэлцэхээс өмнө дөрвөн гомдолд хариуцагч хэвлэл мэдээллийн байгууллагаас залруулга хийсэн байна.

ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ



*ГХАБЖ: ГОМДОЛ ХҮЛЭЭЖ АВАХ, БАРАГДУУЛАХ ЖУРАМ

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БОДЛОГЫН ШИЙДВЭР

2018 онд ХМЗ-ийн Удирдах зөвлөл гурван удаа хуралдаж үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах, гүйцэтгэлд хяналт тавих, Ажлын албанд чиг үүрэг өгөх ажлуудыг гүйцэтгэсний сацуу дараах бодлогын шийдвэрүүдийг гаргав.

- 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийг тодорхойлж, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинг сайжруулах ялангуяа гүтгэх зөрчилтэй холбоотой асуудлаар санал санаачилгатай ажиллах үүргийг ажлын албанд үүрэг болгов.
- ХМЗ-ийн бүрэн эрхийн хугацаанд сонгуульт үүргээ биелүүлж чадахгүйд хүрсэн зарим гишүүдийг чөлөөлж, нөхөн сонгуулийг дүрмийн 7.3, 9.4 дэх заалтын дагуу нэр бүхий гишүүдийг томиллоо.
- ХМЗ-ийн үйл ажиллагааны туршлагад тулгуурлан “Гомдол хүлээн авах, барагдуулах журам”-д 6.2 дахь заалтыг шинээр нэмж оруулав. Энэ нь “Хэрэв гомдол хаяглагдсан хэвлэл мэдээллийн байгууллага хуралдаанаас өмнө залруулгыг нийтэлсэн тохиолдолд хуралдаанаар гомдлыг авч хэлэлцээд шийдвэрийг олон нийтэд мэдээлэхгүй, харин гаргасан алдааг нь тухайн хэвлэл мэдээллийн байгууллагад мэдэгдэж, зөвлөмж хүргүүлнэ” гэсэн заалт юм.

СЭТГҮҮЛ ЗҮЙН ЁС ЗҮЙН ФОРУМ

2018

**МЭРГЭЖЛИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙ
БА ДИЖИТАЛ ЭРИН ҮЕ**

СЭТГҮҮЛ ЗҮЙН ЁС ЗҮЙН
ФОРУМ
ХОЁР ДАХЬ ЖИЛДЭЭ

JEE 2018
Journalism Ethics Forum

**2018 ОНЫ 10-Р САРЫН 23-НЫ ӨДӨР
ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛД БОЛНО.**

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ
Хэвлэл мэдээллийн зөвлөл

ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧ
FRIEDRICH EBERT STIFTUNG

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД
DW Akademie Made for minds. МОНГОЛTV gogo NEWS AGENCY

2018 оны аравдугаар сарын 23-нд Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс санаачлан Сэтгүүл зүйн ёс зүйн хоёрдугаар форумыг “Мэргэжлийн сэтгүүл зүй ба дижитал эрин үе” сэдвийн хүрээнд Фридрих Эбертийн Сангийн дэмжлэгтэйгээр зохион байгууллаа. Дэмжигч байгууллагаар ХБНГУ-ын Дойче Велле Академи, Монгол ТВ, GoGo Агентлаг хамтран ажилласан юм.

Форумын үеэр дараах сэдвүүдийн хүрээнд үндсэн болон туслах илтгэлүүд, панел хэлэлцүүлгүүд боллоо.



- Цахим орчинд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөрийгөө зохицуулж буй туршлагын талаар
- Сошиал медиагаас мэргэжлийн сэтгүүл зүй хэрхэн ялгарах вэ, дижитал эринд сэтгүүл зүй ямар байх вэ?
- Редакцид харьяалагдаж байгаа сэтгүүлч сошиал хаягаараа байр сууриа илэрхийлж болох уу?
- Сэтгүүл зүй болон сошиал медиагийн уялдааг дэлхийн улс орнууд хэрхэн зохицуулж байна вэ?





ҮР ДҮН:

Сэтгүүл зүйн ёс зүйн форумаар хөндсөн сэдвүүд хэвлэл мэдээллийн салбарын анхаарлын төвд байж, мэргэжлийн сэтгүүл зүй болон сошиал медиагийн ялгаа, заагийг тодорхой болгоход хувь нэмэр оруулсан.

Түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагууд энэ талаар санал, санаачилга дэвшүүлэн мэргэжлийн сэтгүүл зүйн ялгаа заагийг тодруулсан мэдээ, нийтлэл, сурвалжлага түгээж салбартаа мэргэжлийн ёс зүйн зарчмаа мөрдөж ажиллахыг уриалав.

Форумаар дэвшүүлсэн уриалгад news.mn; gogo.mn; ikon.mn; zindaa.mn; peak.mn нэгдээд байна.



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГО

ЦУВРАЛ ХЭСЭЛЦҮҮСЭГ

ЗОРИЛГО:

Фридрих Эбертийн Сантай хамтран “Хэвлэл мэдээллийн бодлого” цуврал дугуй ширээний ярилцлагыг эхлүүллээ. Хэлэлцүүлгийн зорилго нь хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинд тулгамдаж буй бодлогын асуудлуудыг хөндөх, сэтгүүл зүйн салбарын ёс зүйн хүрээний шинэ сорил, бэрхшээлүүдийг оролцогч талуудтай хэлэлцэн шийдлийг дэвшүүлэхэд чиглэж байна.

ҮР ДҮН:

Дээрх хэлэлцүүлгийн үр дүнд тулгуурлан Сэтгүүл зүйн ёс зүйн форумыг “Мэргэжлийн сэтгүүл зүй ба дижитал эрин үе” сэдвийн хүрээнд зохион байгуулсан нь үр дүнтэй байлаа. Эндээс цахим сайтууд дижитал эрин үед мэргэжлийн түвшинд ажиллах, ёс зүйн зарчмаа чанд мөрдөх талаар уриалга гаргаж, цахим сайтуудын төлөөллүүд нэгдсэн юм. Мөн социал медиатай хэрхэн харьцах, мэдээ нийтлэлдээ үзэн ядах үг хэллэг ашиглахгүй байх тухай редакцийн дотоод дүрэм журамтай болохыг хэвлэл мэдээллийн байгууллагуудад сануулав.

"Хэвлэл мэдээллийн бодлого" цуврал хэлэлцүүлгийн хүрээнд дараах сэдвүүдийг хөндөв.

■ 2018 оны гуравдугаар сарын 28-нд "Зөрчлийн хууль ба хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт" сэдэвт хэлэлцүүлэг хийв. Хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн Х.Нямбаатар, ЦЕГ, УПЕГ, Монголын Хуульчдын Холбоо, Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Глоб Интэрнейшнл Төв болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл оролцсон юм. Эндээс улбаалан гүтгэх зөрчлийг хэрхэн зохицуулах гарц шийдлийг эрэлхийлсэн үйл ажиллагаануудыг санаачлан зохион байгууллаа.

■ 2018 оны есдүгээр сарын 21-нд цахим орчин дахь үзэн ядалтын үг хэллэгийн судалгааны үр дүнд түшиглэн цахим сайтууд дахь өөрийн зохицуулалтын талаар хөндөн ярилцав. Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнхэд доромж үг, үзэн ядалтын үг хэллэгийг ашиглаж хүний нэр төрийг гутаасан гэх гомдлууд зонхилдог. Мөн агуулгын судалгаагаар цахим орчин дахь сэтгүүл зүйн бүтээлүүд болон уншигчдын сэтгэгдлийн хэсэгт агуулагдаж буй үзэн ядалтын үг хэллэгийн өнөөгийн нөхцөл байдлыг тодруулж, гарц шийдлийг хэлэлцэв.



ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНД НИЙЦҮҮЛЭН ГҮТГЭЛГИЙГ ЗОХИЦУУЛАХ НЬ

Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчныг сайжруулах, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах, эрх зүйн орчныг бий болгох, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг баталгаажуулахад хууль шүүхийн байгууллагуудтай хамтран ажиллах, харилцан мэдлэг туршлагаа солилцох шаардлагатай болсон.

- 2018 оны нэгдүгээр сарын 9-нд Налайх болон Багахангай дүүргийн шүүгч, прокуроруудад “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт” сэдвээр сургалт хийв.
- 2018 оны тавдугаар сарын 22-нд Хэвлэл мэдээллийн зөвлөл, Монголын хуульчдын холбоо, Глоб интернэшнл төв хамтын ажиллагааны санамж бичгийг үзэглэв.
- 2018 оны зургаадугаар сарын 19-нд Хэвлэл мэдээллийн зөвлөл “Хуульчдын форум-2018”-д урилгаар оролцож, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үр өгөөжийн талаар танилцууллаа.
- 2018 оны зургаадугаар сарын 20-нд зохион байгуулсан “Хэвлэл мэдээлэлд өөрийгөө зохицуулах боломж бий юу” сургалтыг зохион байгуулав. Сургалтад Монголын хуульчдын холбооны гишүүд, сургагч багшаар бэлтгэгдэж байгаа хуульчид хамрагдсан юм.
- 2018 оны зургаадугаар сард ХМЗ-ийн удирдах зөвлөлийн гишүүдийн төлөөлөл УИХ-ын зарим гишүүд болон ЦЕГ-ын удирдлагуудтай хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, гүтгэх зөрчлийн асуудлаар санал солилцов.
- 2018 оны арванхоёрдугаар сарын 12-нд Нийслэлийн эрүүгийн болон иргэний хэргийн анхан шатны шүүгч нарт “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь” сэдэвт дугуй ширээний ярилцлага хийв. Энэ үеэр МУИС-ийн хууль зүйн сургуулийн багш, доктор О.Мөнхсайхан, ХБНГУ-ын хэвлэлийн зөвлөлийн орлогч дарга Манфред Протце нар итгэл тавьж, туршлага хуваалцлаа.



■ 2018 оны арван хоёрдугаар сарын 20, 21-нд “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө: олон улсын шүүхийн практик” сургалтыг шүүгч, прокуроруудад, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө: олон улсын хэм хэмжээ” сэдвээр хэвлэл мэдээллийн эрх зүйгээр мэргэшиж буй сургагч багш нарт сургалт хийв. Хоёр өдрийн сургалтыг ОХУ-ын Олон нийтийн хэвлэл мэдээллийг хамгаалах төвийн захирал, ахлах хуульч Галина Арапова удирдан явууллаа.

■ 2018 оны арван хоёрдугаар сарын 21-ээс 24-ний өдрүүдэд Хэвлэл мэдээллийн салбарын мэргэжлийн байгууллагууд болон эвсэл холбоодтой хамтран Зөрчлийн хуулийн 6.21 дэх Гүтгэх зөрчлийг эсэргүүцсэн шаардлагыг Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлэхэд хамтран ажиллаж дэмжин оролцлоо.



ҮР ДҮН:

Дээрх үйл явдлуудаас дүгнэхэд сэтгүүлчид үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нэр төр, хувийн нууцад халдах, бусдыг гүтгэх, гутаах, доромжлохыг хуулиар оновчтой зохицуулахад Монголд суурь судалгаа дутмаг байна. Түүнчлэн хэвлэл мэдээллийн болон шүүхийн түвшинд ойлголтын зөрүүтэй, салбарын хүрээнд хуулийн гарц гаргалгааг үндэслэлтэйгээр тооцож боловсруулсан бодлогын баримтууд дутагдалтай нь харагдаж байв. Иймээс Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар сэтгүүлчид шийтгэл ногдуулсан кейсүүдэд хараат бус хуульч, судлаачаар анализ хийлгэхээ болсон юм.

СЭТГҮҮЛЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МОНИТОРИНГ

Хэвлэл мэдээллийн зөвлөл, Глоб интернэшнл төв хамтран Монголын сэтгүүлчдийн аюулгүй байдлын түвшинг тодорхойлох зорилгоор 300 сэтгүүлчдийн дунд санал асуулгын судалгаа хийлээ. Тус судалгааг 2018 оны 8 дугаар сараас 2019 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд хийсэн. Мөн судалгааны үр дүнгийн талаар 2018 оны 11 дүгээр сар болон 2019 оны 5 дугаар сард тус бүр танилцуулсан юм. Уг судалгааны агуулга, хамрах цар хүрээг нэмэгдүүлж, цаашид тогтмол хийж байхаар төлөвлөж байна.

СЭТГҮҮЛЧДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУД



Сэтгүүлч гэж олон нийтийн эрх ашгийн төлөөх сэтгүүл зүйн бүтээл ихээр туурвидаг мэргэжлийн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, нийгмийн сүлжээний контент үйлдвэрлэгчдийг хэлнэ. ЮНЕСКО-гийн тодорхойлолтоос:

Сэтгүүлчдэд мэдээлэл өгөхөөс татгалзаж байна

Төрийн албан тушаалтан “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу мэдээлэл өгөхөөс татгалзаж байсан тохиолдол 10 сэтгүүлч тутмын 7-д дор хаяж нэг удаа тохиолдож байсан.



• Төрийн байгууллага нь нууцад хамаарах мэдээллийн жагсаалтаа дотоод зохион байгуулалтын хүрээнд гаргадаг ба хэт ерөнхий хүрээнд тодорхойлсон байдаг. Энэ нь тухайн байгууллага өөрийн цензурээр мэдээллийг нууц гэж томъёолж, мэдээлэл олж авах, түгээхэд саад хийх нөхцөлийг бүрдүүлж байна.

Заналхийлэл улам гаарч байна

Нийт сэтгүүлчийн 67 хувь нь бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болоод ямар нэгэн дарамт, сүрдүүлэгт дор хаяж нэг удаа өртөж байсан.



• Сэтгүүлч бичсэн нийтлэл, олон нийтэд түгээсэн мэдээллээсээ болж утсаар заналхийлэлд өртөх, сэтгүүлч болон редакцийн бусад гишүүдийг айлгаж дарамтлах, олны өмнө доромжлох, эрх мэдэл бүхий өндөр албан тушаалтан дарамтлах зэрэг нь хамгийн түгээмэл ба нэг сэтгүүлч дунджаар 3-4 удаа энэ төрлийн заналхийлэлд өртөж байжээ.

Ажлын багаж хэрэгсэлд халдаж байна

Судалгаанд хамрагдсан нийт сэтгүүлчийн 58 хувьд ажлын багаж хэрэгсэлд халдах тохиолдол дор хаяж нэг удаа тохиолдож байсан.



• Сэтгүүлчийн бэлтгэсэн мэдээ, мэдээллийг цааш задруулахгүй байх зорилгоор камерыг булаах, эвдлэх, мемори картан дахь мэдээллийг устгах зэрэг ажлын багаж хэрэгсэлд халдах явдал гардаг.

Редакцийн цензур хүчтэй хэвээр байна

Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх төрлийн цензур нийт сэтгүүлчийн 52 хувьд буюу хоёр сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байсан.



• Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх төрлийн цензур нийт сэтгүүлчийн 52 хувьд буюу хоёр сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байсан.

Нууц эх сурвалжаа илчлэхийг албадаж байна

Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдол нийт сэтгүүлчийн 51 хувь буюу хоёр сэтгүүлч тутмын нэгд тохиолдож байжээ.



• Сэтгүүлчийн бичсэн мэдээ, нийтлэл гарсны дараа нэр дурдагдсан байгууллага болон эрх мэдэл бүхий албан тушаалтан ямар эх сурвалжаас мэдээлэл авсан тухай асуудаг. Мөн сэтгүүлчийн эсрэг шүүхэд гомдол гаргаж, тухайн мэдээллийн баримтаа нотлохыг шаарддаг нь нууц эх сурвалжаа илчлэхээс өөр аргагүй байдалд оруулж байна.

Сэтгүүлчид шүүх, хүчний байгууллагын дарамтад өртөж байна

Судалгаанд оролцогчдоос “Таны бэлтгэсэн нийтлэл, нэвт- рүүлэгтэй холбогдуулан шүүх, цагдаагийн байгууллагад хэрэг үүсгэгдэж байсан уу? гэж асуухад 36 хувь нь буюу гурван сэтгүүлч тутмын нэг нь тийм гэж хариулсан.



• Төрийн байгууллага, төрийн байгууллагын эрх мэдэл бүхий албан тушаалтан, улс төрчид сэтгүүлчдийн эсрэг шүүхэд гомдол гаргах тохиолдол хамгийн их байна. Зөрчлийн тухай хууль батлагдаж, дагаж мөрдөгдөж эхэлснээс хойш гомдол гаргагчдын тоо өссөөр байна.

СЭТГҮҮЛ ЗҮЙН ЧАНАРЫН ЦУВРАЛ

СУРГАЛТ, УУЛЗАЛТУУД - 2018

2 CAP

- Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбооны гишүүдийн хурлын үеэр Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс үйл ажиллагаа, гомдол шийдвэрлэлтийн талаар танилцууллаа.
- ХХЗХ-ны нийт ажилтан албан хаагчдад өөрийн зохицуулалт, ХМЗ-ийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөв.

4 CAP

- “Телевизүүдийн форум 2018”-д ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа оролцож “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт буюу үзэгчийн эрх ашиг” сэдвээр илтгэл тавив.
- ХМЗ-ийн Ёс зүйн хорооны гишүүдэд “Хэвлэл мэдээллийн ёс зүй ба өргөдөл гомдлын менежмент” сургалт зохион байгууллаа.

5 CAP

- “Цахим сэтгүүл зүйн хоёрдугаар форум”-д ХМЗ-ийн төлөөлөгч оролцож, өөрийн зохицуулалтын талаар мэдээлэл өглөө.
- “Хэвлэлийн эрх чөлөөний форум”-д Удирдах зөвлөлийн дэд дарга У.Тамир илтгэл тавьсан. “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын төлөвшил” сэдвээр илтгэл тавив.
- “Хүүхдэд ээлтэй сэтгүүл зүй” сургалтын үеэр ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт ба хүүхэд хамгаалал” сэдвээр илтгэл танилцуулав.

6 CAP

- Дорноговь, Хөвсгөл аймгуудад болсон бүсийн сэтгүүлчдийн семинарт ХМЗ-ийн төлөөллүүд оролцож хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, ёс зүй, шийдвэрлэсэн өргөдөл гомдлын кейсүүдийг танилцуулсан.
- Нийслэлийн Цагдаагийн Газраас зохион байгуулсан “Зарим зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалтад ХМЗ-ийн төлөөлөл оролцож оролцож, “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт ба ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлт” сэдвээр илтгэл тавив.

7 CAP

- “Хүний эрхийг сурвалжлах нь” сэтгүүлчдэд зориулсан сургалтад ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа “Цахим дахь өөрийн зохицуулалт” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

9 CAP

- “Эерэг, аюулгүй, хариуцлагатай цахим орчин” сэдэвт хэлэлцүүлэгт ХМЗ-өөс төлөөлөл оролцож, “Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг, хэвлэлийн өөрийн зохицуулалт” сэдвээр мэдээлэл өглөө.
- ХМЗ-ийн Удирдах зөвлөлийн дарга Ч.Номингийн урилгаар өргөн нэвтрүүлгийн телевизийн удирдлагууд уулзлаа. Тус уулзалтад 15 телевизийн төлөөлөл оролцож, ХМЗ-ийн үйл ажиллагаа, цаашдын чиг хандлагын талаар санал солилцсон юм.

10 CAP

• ХМЗ-ийн гишүүдэд “Хэвлэл мэдээллийн ёс зүй ба өргөдөл гомдлын менежмент” цуврал сургалтыг дахин зохион байгуулав. Сургагчаар зөвлөх Манфред Протце ажиллаж, гомдол барагдуулах журмын хэрэгжилт, ёс зүйн хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагын тухай онцлов.

• “Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хурал”-д ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй дэх сэтгүүлчийн аюулгүй байдал” панел хэлэлцүүлэгт оролцлоо.

Хэвлэл мэдээллийн зөвлөл “Сэтгүүл зүйн чанар ба өөрийн зохицуулалт” сэдвийн хүрээнд сэтгүүл зүйн багш нар, нийслэл болон орон нутгийн сэтгүүлчдийн төлөөлөл багтсан сургалт зохион байгуулав.

11 CAP

• “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн хаалтын сургалтын үеэр ХМЗ-өөс “Зөрчлийн хууль ба салбарын өөрийн зохицуулалт” сэдвээр илтгэл тавьж, панел хэлэлцүүлэгт оролцов.

• МАН-ын гишүүд, олон нийттэй харилцах ажилтнуудад Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, ХМЗ-ийн үйл ажиллагааны талаар Удирдах зөвлөлийн дэд дарга У.Тамир танилцууллаа.

• Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Цахим сэтгүүл зүй ба шинэ тренд- мэргэжлийн ёс зүй” интерактив хоёр өдрийн сургалтыг бие даан зохион байгуулав.

12 CAP

• “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба олон улсын шүүхийн практик” сургалтад ХМЗ-ийн РТВ-ийн Ёс зүйн хорооны дарга Ш.Сүхбаатар “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтаар шийдвэрлэсэн хэргүүд” сэдвээр илтгэл тавьж, оролцогчдод мэдээлэл өглөө.

2018 онд хэвлэл мэдээллийн редакцуудад зочлох, сэтгүүлчдэд ХМЗ-ийн үйл ажиллагааг танилцуулах ажлыг ажлын албанаас үргэлжлүүлэн хийсэн. Үүнд, NTV, SBN, control.mn, pikas. mn, peak.mn, social.mn болон МУИС, МУБИС, ХУИС, СУИС-ийн РТВДС, Отгонтэнгэр ИС-ийн сэтгүүл зүйн багш, оюутнууд багтаж байна.





ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН АЖЛУУД




Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гурван жилийн ойн өдрийг тохиолдуулан нийт гишүүдийн хурлыг зохион байгуулж, ХМЗ-ийн хэрэгжүүлсэн ажлууд болон санхүүгийн тайлангийн талаар танилцуулсан.

2018 оны аравдугаар сард ХМЗ-өөс анхны хэвлэлийн бага хурлыг зарлаж, өнгөрсөн гурван жилийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлууд, үр дүн, ололт амжилтын талаар олон нийтэд нээлттэй мэдээлэл хийв.

Гомдол хүлээж авах, барагдуулах журмын хэрэгжилтийн дагуу ХМЗ-ийн хүлээн авч, шийдвэрлэсэн өргөдөл гомдлуудыг хэрхэн шийдвэрлэсэн талаар долоон удаагийн хэвлэлийн мэдээ бэлтгэж, олон нийтэд нээлттэй танилцуулсан.

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байх бодлогын хүрээнд улирал тутам цахим сэтгүүл гаргаж, олон нийтэд хүргэж байна. Өнгөрсөн онд нийт дөрвөн дугаар гаргаж цахим сүлжээгээр түгээлээ.

МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ ХЭВЛЭМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД



Хэвлэл Мэдээллийн Зөвлөл

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР

2018 онд ХМЗ-ийн үйл ажиллагаа, ёс зүйн хорооны шийдвэр, тус зөвлөлөөс зохион байгуулсан сургалт, арга хэмжээ, форум зэргийн талаар нэр бүхий 59 мэдээллийн цахим сайтад нийт 138 мэдээлэл, өдөр тутмын сонинуудад нийт 8 төрлийн мэдээ нийтлэл гарчээ.

ХМЗ-ийн талаар өдөр тутмын сонинуудаас Өдрийн сонин, Үндэсний шуудан сонин, цахим сайтуудаас ikon.mn; news.mn; zindaa.mn; gogo.mn, dnn.mn хамгийн олон удаа мэдээлжээ.

ДОТООДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛ

2018 онд хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагын тогтвортой хөгжлийг хангахад сар бүр тогтмол мөнгөн хандив үзүүлэх санаачилгыг дараах байгууллагууд дэмжиж, хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Үүнд:

Ньюс Агентлаг ХХК, ОНХМХ, Отгонтэнгэр ИС, Интерактив медиа ХХК, Монгол ТВ ХХК, Монгол Контент ХХК-ийн эрхлэн гаргадаг gogo.mn, Жамух Интернэйшнл ХХК-ийн эрхлэн гаргадаг Зиндаа сэтгүүл, zindaa.mn, А Стар Монголиа

Өргөн нэвтрүүлгийн болон цахим хэвлэл мэдээллийн салбарт ёс зүйн зарчмыг хэвшүүлэх, олон нийтийн мэдэх эрхийн хүрээнд Харилцаа Холбооны Зохицуулах Хороотой 2018 оны нэгдүгээр сарын 24-нд хамтран ажиллах санамж бичиг байгуулав.

Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчныг сайжруулах сургалт, судалгааны ажлуудыг хэрэгжүүлэх, хэвлэл мэдээллийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн сургагч багш нарыг хамтран бэлтгэх санамж бичгийг Глоб Интернэшнл Төв, Монголын Хуульчдын Холбоотой 2018 оны тавдугаар сарын хоёрны өдөр үзэглэсэн.

Монгол Улсын иргэний үнэн бодитой, тэнцвэртэй, хараат бус мэдээлэл олж авах эрхийг хангах чиглэлээр төрийн хууль хяналтын байгууллага болон хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр ЦЕГ, ХМЗ-ийн хамтран ажиллах төлөвлөгөөг 2018 оны тавдугаар сарын 23-нд байгуулсан.



ТУРШЛАГА СОЛИЛЦОХ АЯЛАЛ



■ 2018 оны тавдугаар сард Берлин хотноо болсон “Хэвлэл мэдээллийн нийгэмд гүйцэтгэх үүрэг” олон улсын туршлага судлах хөтөлбөрт 17 орны төлөөлөл хамрагдсанаас ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа оролцов.

■ МСНЭ-ээс 2018 оны есдүгээр сард Өмнөговь аймагт зохион байгуулсан “Хятад Монголын хэвлэл мэдээллийн форум” -д төлөөллүүд оролцов.



■ Казакстаны нийслэл Астана хотноо 2018 оны 11 дүгээр сарын 7-8 нд болсон “Сэтгүүл зүйн ирээдүй” Төв Азийн 20 дахь олон улсын хуралд Удирдах зөвлөлийн дэд дарга У.Тамир оролцлоо.



■ 2018 оны 11 дүгээр сарын 8-наас 12-ны өдрүүдэд БНХАУ-д болсон “Хэвлэл мэдээллийн аялал” хөтөлбөрт төлөөлөгчид хамрагдав.



САНХҮҮЖИЛТ

2018

ОРЛОГО: 146,734,149 төгрөг

ЗАРДАЛ: 137,086,426 төгрөг

I. ХМЗ-ИЙН ОРЛОГЫН БҮРДЭЛТ



II. ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТ



2018 ОНД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ДЭМЖСЭН БАЙГУУЛЛАГУУД:



DEMOCRACY
REPORTING
INTERNATIONAL



+976 7000 0160



www.mediacouncil.mn



info@mediacouncil.mn



Хэвлэл мэдээллийн зөвлөл